



ЗАВХАН АЙМГИЙН 2016 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН



Дүгнэлт: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙГ ҮР АШИГТАЙ, АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ ТӨЛӨВЛӨЖ
ЗАРЦУУЛСАН БАЙНА.

	АГУУЛГА
Тайланг хянасан:	Товчилсон үгийн жагсаалт3
Завхан аймаг дахь Төрийн аудитын газар	Нэг. Ерөнхий зүйл
Газрын дарга,	Аудит хийсэн үндэслэл, хугацаа.....4
Тэргүүлэх	Аудитын зорилт, хамарсан хүрээ.....4
аудитор:	Аудитын арга зүй.....4
Л.Уламбаяр	Завхан аймгийн ТЕЗ-ийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал4
Аудитын менежер:	Хоёр. САНХҮҮГИЙН ДОТООД ХЯНАЛТ5
Б.Дагвасүрэн	Гурав. Шилэн дансны мэдээлэл.....6
Тайланг бэлтгэсэн:	Дөрөв. Материаллаг байдлыг тодорхойлох7
Ахлах аудитор:	Тав. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар7
Г.Хашцэцэг	Зургаа. МӨНГӨН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ
Аудитор:	6.1. Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар7
Б.Бямбасүрэн	6.2 Банкин дахь аймгийн ТЕЗ-ийн харилцах дансны талаар8
Н.Батбилэг	Долоо. Авлагын бүртгэл, тайлагнал
2017 оны 4 дүгээр сар	7.1. Авлагын бүтэц, дамжуулан зээлийн авлагын талаар 10
	7.2. Авлагатай холбоотой зөрчлийн талаар12
	Найм. Бараа материалын бүртгэл, тайлагнал
	8.1. Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар13
	8.2 ОНӨҮГ-ын бараа материал дансны талаар.....14
	8.3 Сумдын ТЕЗ болон орон нутгийн төсөвт байгууллагуудын бараа материалтай холбоотой зөрчлийн талаар.....14
	Ёс. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал
	9.1. Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүний талаар.....15
	9.2 Сумдын ТЕЗ болон орон нутгийн төсөвт байгууллагуудын үндсэн хөрөнгөтэй холбоотой зөрчлийн талаар..... 17
	Арав. Өр төлбөрийн бүртгэл тайлагналын

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70462813,70463783 дугаарын утасаар харилцана уу.

ХАЯГ:

Завхан аймаг дахь Төрийн аудитын газар.
Нутгийн удирдлагын ордон
Өрөө №309,310

10.1. Өр төлбөрийн бүтцийн талаар	18
10.2 Өр, төлбөрийн дансны үлдэгдлийн баталгаажуулалтын талаар.....	19
Арван нэг. Орлогын бүртгэл, тайлагнал	
11.1 Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн талаар	20
11.2 Сумдын ТЕЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	21
Арван хоёр. Зардлын бүртгэл, тайлагнал	
12.1 Зардлын бүртгэлийн талаар	22
12.2 Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар зардалтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар.....	24
12.3 Зардалтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар	24
12.4 Хуримтлагдсан үр дүнгийн талаар	26
12.5 Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлын талаар	26
Арван тав. Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн талаар.....	26
Арван зургаа. Аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн санал, дүгнэлт.....	29
Арван долоо. Тайлант оны аудитын зөвлөмж.....	29

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖМС	Жижиг мөнгөн сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОН	Орон нутаг
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
СТАУС	Санхүүгийн тайлангийн удирдлагын сиситем
СХС	Сум хөгжүүлэх сан
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон Хэнтий аймгийн ТЕЗ-ийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт
УХӨТ	Урт хугацаат өр төлбөр
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХО	Хөрөнгө оруулалт
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудит хийсэн үндэслэл, хугацаа

Завхан аймаг дахь Төрийн аудитын газар Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д заасан бүрэн эрхийн дагуу Завхан аймгийн төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Завхан аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт болон бусад шаардлагын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэж, үнэн шударга илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Завхан аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангууд иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг тэдгээр тайланд хавсаргах ёстой. Эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын зорилт бөгөөд хамарсан асуудлууд болно.

Завхан аймаг дахь Төрийн аудитын газар Завхан аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргахын өмнө Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу 24 сумын төсвийн ерөнхийлөн захирагчдын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

Аудитын арга зүй

Завхан аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, хяналтын сорил, шинжилгээний горим болон нарийвчилсан сорил хийж, ихээхэн дүнтэй ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, санхүүгийн тайлан, түүний тодруулгад үнэлгээ өгөв.

Ингэхдээ санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг үндсэн шалгуур болголоо.

Завхан аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, аргачлал

Завхан аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ УСНББОУС-д заасан зарчим, Төсвийн тухай хуулийн 54.1-54.4 заалт, Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэж гаргах аргачлал”-ыг баримтлан, Төсвийн тухай хуулийн 26.2 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1, 6.1 дэх заалтуудын дагуу нягтлан бодох бүртгэлийн

тохируулсан аккрузль суурийг хэрэглэж, Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж гаргасан байна.

Завхан аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд дараах тайлангуудыг нэгтгэсэн байна. Үүнд:

- Сумын Төсвийн ерөнхийлөн захирагчдын 24 санхүүгийн нэгтгэсэн тайлан
- Орон нутгийн төсөвт 65 байгууллагуудын 2016 оны санхүүгийн тайлан
- Тусгай зориулалтын шилжүүлгийн 118 байгууллагын 2016 оны санхүүгийн тайлан
- Төрийн өмчит үйлдвэрийн газар 3 байгууллагын 2016 оны санхүүгийн тайланд
- Орон нутгийн өмчит үйлдвэрийн 4 газрын 2016 оны санхүүгийн тайлан
- 54 Төсөл, сангуудын 2016 оны санхүүгийн тайлан
- Завхан аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дараах бүрэлдэхүүнтэй:

А. Үндсэн тайлан:	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
Завхан аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн байдлын тайлан	НББ-ийн бодлого, зарчим
Завхан аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн тайлан	Толилуулгын суурь
Завхан аймгийн ТЕЗ-ийн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх мөнгөн гүйлгээний тайлан	
Завхан аймгийн ТЕЗ-ийн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	

Дээрх тайлангуудыг Сангийн сайдын 2015 оны 341 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу “Э-тайлан” програмаар бэлтгэн гаргажээ.

Хоёр. Санхүүгийн дотоод хяналт

Төсвийн тухай хуулийн 14.2.10-т “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлнэ” гэж заасныг баримтлан Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2016 онд зарим сумдын 2015, 2016 оны эхний хагас жилийн санхүүд дотоод аудит хийж, төсвийн тухай хууль, түүнтэй холбогдон гарсан журмын хэрэгжилтийн дүнд

нийтлэг илэрсэн зөрчил дутагдалыг засч, сайжруулах чиглэлээр зөвлөмж өгч ажилласан байна.

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дотоод хяналтын эрсдэл “Хэвийн” гэж үнэллээ.

Гурав. Шилэн дансны мэдээлэл

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь “Шилэн дансны тухай” хуулийн 8.2, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журамын 8.3 заалтыг удирдлага болгон хяналтыг хэрэгжүүлж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтэд шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийг хугацаанд нь тавьж байгаа эсэх болон мэдээллийн үнэн зөв бодитой байдалд сүлжээгээр тандан судлах, хяналт хийх удирдамж боловсруулан ажиллажээ.

Мөн Аудитын газраас Үндэсний аудитын газрын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 4,11-р саруудад нийцлийн аудитыг хийсэн.

Аймгийн хэмжээнд 2016 оны байдлаар 212 төсөвт байгууллага, 25 төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөл хөтөлбөр, Сайдын төсвийн багцын 3 сан, Төрийн өмчийн 9 ААН, төсвөөс татаас авсан аж ахуйн нэгж буюу нийт 265 нэгж байгууллага шилэн дансны нэгдсэн цахим системд бүртгэгдэн мэдээлэл байршуулж байна.

Аймгийн Аудитын газраас хийсэн нийцлийн аудитын дүнгээр Шилэн дансны тухай хуулийн 3.1.1-3.1.3-д заасан байгууллагуудын 2016 оны 3-р улирлын Шилэн дансны хуулийн хэрэгжилт дунджаар 85-95 хувьтай байгаа бөгөөд Төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг хууль тогтоомжийн гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 2 хувийн цэцэрлэг, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа 28 аж ахуйн нэгж байгууллагууд өөрийн цахим хуудсыг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулаагүй байна

Аудитаар Шилэн дансны нэгдсэн цахимд өөрийн байгууллагын цэсгүй Төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг хууль тогтоомжийн гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 2 хувийн цэцэрлэг, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа 28 аж ахуйн нэгж байгууллагууд, 2-3 мэдээлэл оруулсан аймгийн ИТХ, Тэс сумын төсвийн ерөнхийлөн захирагч буюу төрийн санд албан шаардлага, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч буюу Засаг дарга, шилэн дансны мэдээллээс 4-5 мэдээлэл оруулсан 4 байгууллагад зөвлөмж хүргүүлээ.

Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2016 оны сүүлээр хийгдсэн шалгалтын дүнгээр 265 нэгж байгууллага нийт 36132 удаагийн мэдээлэл байршуулах ёстойгоос 32385 удаагийн мэдээлэл байршуулж хэрэгжилт 89,6 хувьтай байна гэж мэдээлжээ.

Шалгалтын явцад байгууллагын болон хувийн мэдээллээ шинэчлээгүй байгууллагуудад албан тоот хүргүүлж, заавар зөвлөмж өгч ажиллажээ.

Хэдийгээр Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт тавьж ажилладаг боловч аудитад хамрагдсан байгууллага, этгээд нь мэдээллийг бүрэн, үнэн зөв оруулдаггүй, хагас дутуу оруулдаг, эсвэл байхгүй гэж мэдээлдэг, төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгааны тайлбарыг оруулдаггүй, хугацаа хоцроож мэдээлдэг зөрчил дутагдал нийтлэг байна.

Дөрөв. Материаллаг байдлыг тодорхойлох

Завхан аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2016 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт орлогын дүнг суурь болгон авч түүний 1.0 хувиар тооцон 1042,2 сая төгрөгөөр тогтоов.

Тав. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар

Аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд бүх Орон нутгийн төсөвт байгууллага, Төрийн сан, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, Төсөл, сангуудын нэгтгэлийн дүнг тус тусад нь баганаар харуулжээ.

ТЕЗ-ийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг тэдгээр тайланд хавсаргасан байна.

Төсвийн тухай хуулийн 8.9.4-т “Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасан бөгөөд Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанаас 12 хоногоор хоцроож 2017 оны 04-р сарын 12-ны өдөр excel файл, болон цаасан хэлбэрээр ирүүлсэн бөгөөд СТАУС програмд оруулж уялдааг шалгахад зөрүүгүй таарч байна.

Зургаа. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

6.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- ТЕЗ-ийн төрийн сангийн дансны үлдэгдэл, арилжааны банкуудад байршдаг зарим төсвийн байгууллагын жижиг мөнгөн сан, харилцах дансдын үлдэгдэл, ОНӨҮГ-ууд, төсөл сангийн төгрөгийн болон гадаад валютаарх харилцах дансдын үлдэгдлийг тайлагнажээ
- Кассад байгаа бэлэн мөнгө.

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2015 оны эцэст 2942,8 сая төгрөг байснаас 9,9 хувиар өсч 3236,7 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд үүний 1,9 хувь буюу 60,7 сая төгрөг нь арилжааны банкинд байршиж байна.

ТЕЗ-ийн төсвийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2016 оны үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
Кассад байгаа бэлэн мөнгө	128,8	5,0	-123,8	288,2
Төгрөг/ЖМС	128,8	5,0	-123,8	288,2
Нэмэлт санхүүжилтийн Касс			-	
Банкинд байгаа бэлэн мөнгө	2813,9	3231,7	417,8	14,6
Төгрөг	2813,9	3231,7	417,8	14,6
Төрийн сангийн харилцах	2492,3	2998,2	505,9	20,3
Арилжааны банкин дахь харилцах	259,3	60,7	-198,6	134,1
Нэмэлт санхүүжилтийн харилцах	62,3	172,8	110,5	177,4
Гадаад валют				
Замд яваа мөнгөн хөрөнгө				
<u>Нийт мөнгөн хөрөнгийн дүн</u>	<u>2942,8</u>	<u>3236,7</u>	<u>293,9</u>	<u>9,9</u>
Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:				
Төрийн сан	1667,6	1439,9	-227,7	13,7
Төсөвт байгууллагууд	721,1	817,7	96,6	13,4
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	33,7	49,6	15,9	47,2
Төсөл, сангууд	520,3	929,5	309,2	78,6

Оны эхний үлдэгдэлтэй харьцуулбал: Төсөвт байгууллагуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 96,6 сая төгрөгөөр, төсөл сангуудынх 309,2 сая төгрөгөөр, ОН-ын өмчит үйлдвэрийн газруудынх 15,9 сая төгрөгөөр өссөн, төрийн сангуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 227,7 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант онд ОН-ын татварын орлого 924,4 сая төгрөгөөр давж биелэгдсэн болон ОН-ын төсвийн зарлагын гүйцэтгэл 2288,5 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулагдсантай холбоотой байна.

6.2 Банкин дахь Завхан аймгийн ТЕЗ-ийн харилцах дансны талаар

Сангийн яамны Төрийн сангийн газраас Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6-д заасны дагуу Монголбанк, банкинд төсвийн байгууллагын дансыг нээх, хаах, улсын төсвийн орлогын “тэг” үлдэгдэлтэй данс байршуулах зөвшөөрөл олгох харилцааг зохицуулах зорилгоор “Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монголбанк, банкинд нээх, хаах журам”-ыг шинээр

боловсруулан Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2013 оны 24/24/А-9 дүгээр хамтарсан тушаалаар батлуулан мөрдөн ажилласан байна.

Арилжааны банкуудад байршиж буй харилцах дансыг аймгийн ТЭЗ-ийн төсвөөр хураангуйлан харуулбал: /сая.
Төгрөгөөр/

№	Сумын нэр	Нийт дүн	Үүнээс				Данс ны тоо	Үүнээс	
			Төрийн сан	Төсөвт байгууллага	Төсөл сан	ОНӨҮГ		байг аа	хааг дсан
1	Аймгийн төрийн сан	50.7		1.1		49.6	11	11	
2	Баянхайрхан	1.0	1.0				1	1	
3	Тосонцэнгэл	0.01		0.01			1	1	
4	Нөмрөг	0.08		0.06	0.02		2	1	1
5	Отгон	1.4			1.4		1	1	
6	Сонгино	6.8			6.8		1		1
7	Улиастай	0.06		0.06			1		1
8	Цагаанхайрхан	0.7	0.7				1	1	
10	Сантмаргац	0.04	0.04				1	1	
11	Асгат	0.006		0.006			1	1	
	Нийт дүн	60.7	1.74	1.23	8.2	49.6	21	18	3

Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ” гэж заасныг зөрчиж, Сангийн яамны зөвшөөрөлгүйгээр Улиастай сумын 1-р сургууль, Нөмрөг сумын сургууль, Сонгино сумын СХС, Дөрвөлжин сумын байгаль хамгаалах сангийн дансыг арилжааны банкинд харилцах данс нээж, гүйлгээ хийж байсныг хааж, төрийн санд байршуулсан байна.

Одоогоор арилжааны банкинд байршиж байгаа дансад нь ОНӨҮГ, төрийн сан, Ахмадын хороо, Хот тохижилт үйлчилгээний алба, Өрхийн эмнэлгүүдийн үлдэгдэлтэй дансууд байна.

Санхүү байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлийг төсвийн байгууллагуудаас хүлээн авсан санхүүгийн тайлантай тулган баталгаажуулахад зөрүү илрээгүй болно.

ТЭЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн салбар байгууллагуудад хийсэн аудитаар мөнгөн хөрөнгийн данстай холбоотой 263,4 сая төгрөгийн зөрчил илэрч, тохиолдсон байх, толилуулга ба тодруулга, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна. Үүнд:

- Алдархаан сумын ЗДТГ 1,1 сая төгрөгийг, Дөрвөлжин сумын ЗДТГ 3,8 сая төгрөгийг, Баянхайрхан сумын ЗДТГ 3,3 сая төгрөгийг,

Боловсролын газар 2,6 сая төгрөгийг, Асгат сумын цэцэрлэг 0,5 сая төгрөгийг, Дөрвөлжин сумын цэцэрлэг 1,5 сая төгрөгийг, Тосонцэнгэл сумын 4-р цэцэрлэг 0,5 сая төгрөгийг, Алдархаан сумын сургууль 6,7 сая төгрөгийг, Завханмандал сумын сургууль 14,1 сая төгрөгийг, 4-р сургууль 7,5 сая төгрөгийг тус тус анхан шатны баримтгүйгээр зарцуулсан.

- Яруу сумын ЗДТГ төсвийн шууд захирагчийн хувийн дансанд 7,5 сая төгрөгийг шилжүүлж мод, түлээ бэлтгэсэн, “Амь-Ус трейд” ХХК 30,9 сая төгрөгийг захирлуудын дансанд шилжүүлж хөрөнгө бэлтгэсэн.
- Аймгийн Засаг даргын нөөц сангаас 6 төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд зориулж 18,0 сая төгрөгийг олгосон.
- Аймгийн ЗДТГ төсвийн урсгал санхүүжилтийн болон нэмэлт санхүүжилтийн дансаар гадны 140,6 сая төгрөгийг дамжуулан гүйлгээ хийсэн

Дээрх алдаа зөрчлийн 43,8 сая төгрөгт төлбөрийн акт тогтоож, 79,0 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж, 140,6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдлөө.

Долоо. Авлагын бүртгэл, тайлагнал

7.1 Авлагын бүтэц, бүрэлдэхүүний талаар

Аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 5977.5 сая төгрөг байснаас тайлант онд 355.5 сая төгрөгөөр буюу 5.9 хувиар буурч, оны эцэст 5622.0 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Нийт авлагын үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр нь харуулбал:

(сая төгрөгөөр)

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгд эл	Эцсий н үлдэгд эл	Зөрү ү	Хуви а р
Ажиллагчидтай холбогдсон авлага	12,0	36,8	24,8	206,7
Төлбөртэй үйлчилгээний авлага	157,9	158,9	1,0	0,6
Дансны авлага /ТӨҮГ/	52,0	113,6	61,6	118,4
Татаас санхүүжилтийн авлага	0,06	1,2	1,14	1900
Байгууллагаас авах авлага	205,3	207,6	2,3	1,1
Хувь хүмүүсээс авах авлага	5550,3	5103,8	446,5	8,1
НИЙТ ДҮН	5977,5	5622,0	355,5	6,0
Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:				
Төрийн сан	153,7	153,7	0	0


Төсөвт байгууллагууд	206,5	281,2	74,7	25,3
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	102,7	180,7	78,0	75,9
Төсөл, сангууд	5482,2	5006,5	-475,7	8,7

Авлагын дансны үлдэгдлийг байгууллагын төрлөөр авч үзвэл нийт авлагын 2,7 хувийг төрийн сан, 5,0 хувийг төсөвт байгууллага, 3,2 хувийг ОНӨҮГ, 89,1 хувийг төсөл, сангийн авлага эзлэж байна. Төсөл сангийн авлагын үлдэгдэл нь сумдын СХС-ийн авлага байна.

Нийт авлагыг сум тус бүрээр хүснэгтээр харуулбал: (сая төгрөгөөр)

Сумын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	хувь
Алдархаан	218.7	222.3	3,6	1,6
Асгат	170.5	169.3	-1,2	0,8
Баянтэс	185.6	170.6	-15,0	8,1
Баянхайрхан	212.7	176.9	-35,8	16,8
Дөрвөлжин	165.6	136.5	-29,1	17,6
Завханмандал	182.9	147.1	-35,8	19,6
Идэр	176.0	163.2	-12,8	7,3
Их Уул	319.6	295.2	-24,4	7,6
Нөмрөг	175.1	170.0	-5,1	2,9
Отгон	220.8	226.2	5,4	2,4
Сантмаргац	159.6	142.8	-16,8	10,6
Сонгино	163.7	162.8	-0,9	0,6
Тосонцэнгэл	502.3	508.5	6,2	1,2
Тидэвтэй	173.2	142.4	-30,8	17,8
Тэлмэн	147.1	145.3	-1,8	1,2
Тэс	217.8	189.9	-27,9	12,8
Улиастай	933.3	882.2	-51,1	5,5
Ургамал	156.2	98.6	-57,6	36,9
Цагаанхайрхан	178.7	173.7	-5,0	2,8
Цагаанчулуут	171.2	182.7	11,5	6,7
Цэцэн-Уул	175.1	153.7	-21,4	12,3
Шилүүстэй	229.1	227.3	-1,8	0,8
Эрдэнэхайрхан	143.9	79.1	-54,8	45,0
Яруу	178.7	182.3	3,6	2,0
Аймгийн төрийн сан	420.3	473.3	53,0	12,6
Дүн	5977.7	5621.9	-355,8	6,0

Завхан аймгийн ТЕЗ-ийн 2016 оны нийт авлагын үлдэгдэлийг сум тус бүрээр графикаар харуулбал:



7.2 Авлагатай холбоотой зөрчлийн талаар

Аймгийн ТЕЗ-ийн орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар авлагын данстай холбоотой нийт 1829,6 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д заасан “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй буюу үнэн зөв байдал, толилуулга, эрх ба үүрэг, хэмжилт, иж бүрэн байх гэсэн батламж мэдэглийг хангаагүй, Сангийн сайдын 388 дугаар тушаалаар баталсан НББ-ийн зааврыг зөрчсөн байна. Үүнд:

- Он дамжсан олон жилийн насжилттай 1772,4 сая төгрөгийн авлага. Үүнээс: аймгийн төрийн санд бүртгэлтэй 153,7 сая төгрөг нь 2001 оноос дамжсан эзэн тодорхойгүй, Сумдын СХС-ийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 1612,0 сая төгрөг байна.
- “Амь-Ус трейд” ХХК 6,7 сая төгрөгийн он дамжсан авлагыг барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй, 0,3 сая төгрөгийн авлага дутуу бүртгэсэн.
- Хот тохижилт үйлчилгээний алба 2,0 сая төгрөгийн, БОАЖГ 2,9 сая төгрөгийн, Орон нутгийн өмчийн газар 3,0 сая төгрөгийн авлагыг үндэслэлгүйгээр үүсгэсэн.
- Хөрөнгө оруулалтын техник хяналтын зардлын хөрөнгөөс ХО-ын ажлуудын зураг төсөв, экспертиз хийлгэх, зохиогчийн хяналтын зардал хийлгэх зэрэгтэй холбоотой 24,5 сая төгрөгийг гаргасан боловч холбогдох газруудаас авахаар авлага үүсгээгүй.
- Хүмүүний амьдрах ухааны төв 0,04 сая төгрөгийн НДШ-ийн авлагыг, Нөмрөг сумын ЗДТГ 2,5 сая төгрөгийн халаалтын зардлын урьдчилгааг авлагаар бүртгэлд тусгаагүй байна.

Дээрх алдаа зөрчлөөс 5,4 сая төгрөгийн алдааг залруулж, бусад алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

Найм. Бараа материалын бүртгэл, тайлагнал.**8.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар**

Аймгийн ТЭЗ-ийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт бараа материалын эхний үлдэгдэл 4606,7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4845,5 сая төгрөгөөр тайлагнагдаж, тайланд онд 238,8 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт бараа материалын үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр нь харуулбал:

(сая.төгрөгөөр)

Бараа материалын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувь
Тусгай зориулалтын материал	338,7	346,3	7,6	2,2
Эм боох материал	80,6	73,7	-6,9	8,6
Дуусаагүй үйлдвэрлэл	30,5	16,5	-14,0	46,0
Бэлэн бүтээгдэхүүн	11,5	11,8	0,3	2,6
Бичиг хэргийн материал	235,8	230,3	-5,5	2,4
Аж ахуйн материал	1163,8	1223,8	60,0	5,2
Сэлбэг хэрэгсэл	63,5	56,6	-6,9	10,9
Түлш шатхуун, тослох материал	464,3	485,5	21,2	4,6
Барилга засварын материал	88,0	114,9	26,9	30,5
Хүнсний материал	341,2	401,2	60,0	17,6
Бусад хангамжийн материал	1332,9	1491,5	158,6	11,9
Мал амьтад	455,9	393,3	-62,6	13,8
Нөөцийн бараа	0	0		
НИЙТ ДҮН	4606,7	4845,5	238,8	4,5
Төрийн сан	0	0		
Төсөвт байгууллагууд	4551,5	4777,5	226,0	5,0
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	55,2	68,0	12,8	23
Төсөл, сангууд				

Бараа материалын өсөлтийг нэр төрлөөр нь авч үзвэл, аж ахуйн материал 60,0 сая төгрөгөөр, хангамжийн материал 158,6 сая төгрөгөөр, тусгай зориулалтын материал 7,6 сая төгрөгөөр, шатах тослох материал 21,2 сая төгрөгөөр өссөн бол, эм боох материал 6,9 сая төгрөгөөр, бичиг хэргийн материал 5,5 сая төгрөгөөр, сэлбэг хэрэгсэл 6,9 сая төгрөгөөр, мал амьтад 62,6 сая төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант онд нийт бараа материалын данс 238,8 сая төгрөгөөр нэмэгдсэнээс төсвийн болон өөрийн хөрөнгөөр худалдаж авсан 6279,6 сая төгрөгийн, хандив тусламжаар 138,3 сая төгрөгийн, шилжүүлж авсан 163,7 сая төгрөгийн бараа материал байгаа бол бусад хэлбэрээр 104,1 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэн байна.

8.2 ОНӨҮГ-ын бараа материал дансны талаар

ОНӨҮГ-ын бараа материалын жилийн эцсийн үлдэгдэл 68,0 сая төгрөг байгаагаас “Амь-Ус трейд” ХХК-д 63,6 сая төгрөг буюу 93,5 хувь, үлдэх 4,4 сая төгрөг буюу 6,5 хувийг “Очир-Илч” ОНӨҮГ-ын хөрөнгө эзэлж байна. ОНӨҮГ-ын бараа материал нь 2016 оны нийт бараа материалын үлдэгдэлийн 1,4 хувийг эзэлж байна.

8.3 Сумдын ТЕЗ болон орон нутгийн төсөвт байгууллагуудын бараа материалтай холбоотой зөрчлийн талаар

Аудитаар үнэгүй ирсэн бараа материалыг төсвийн хөрөнгөөр авснаар бүртгэсэн, данс бүртгэлд орлого авалгүй шууд зардалд бүртгэсэн, дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн, шатахууныг жолоочийн тооцоо бодохгүйгээр олгодог зэрэг нийт 84,7 сая төгрөгийн зөрчил илэрч, толилуулга ба тодруулга, хэмжилт, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан НББ-ийн зааварыг зөрчсөн байна.

/Зөрчлийг доорх хүснэгтээр харуулав/

(сая. төгрөгөөр)

Сумын нэр	Байгууллагын нэр	Дансны нэр	Зөрчлийн утга	Мөнгөн дүн	Аудитаар авсан арга хэмжээ
Улиастай сум	Аймгийн ХЖТ	Бараа материал	Үнэгүй ирсэн бараа материалыг төсвийн хөрөнгөөр авснаар бүртгэсэн	1.0	Зөвлөмж өгөх
Их-Уул	ЗДТГ	Бараа материал	Үнэгүй ирсэн бараа материалыг бүртгээгүй	5.3	Залруулсан
Тосон цэнгэл	Тосон-Очирт хайрхан	Бараа материал	Дутуу бүртгэсэн	2.6	Залруулсан
САНТ	ЗДТГ	Бараа материал	Шууд зардалд хаасан	0.7	зөвлөмж өгсөн
Тэс	ЗДТГ	Бараа материал	шууд зардалд хаасан	0.2	зөвлөмж өгсөн
Яруу	ЗДТГ	Бараа материал	шууд зардалд хаасан	0.2	зөвлөмж өгөх
Түдвэтэй	сургууль	Бараа материал	шууд зардалд хаасан	3.8	зөвлөмж өгөх

Цэцэн-Уул	Сургууль	Бараа материал	шууд зардалд хаасан	2.3	зөвлөмж
Улиастай	4 дүгээр сургууль	Бараа материал	шууд зардалд хаасан	6.1	зөвлөмж
Улиастай	Орон нутгийн өмчийн газар	Бараа материал	шууд зардалд хаасан	1.1	зөвлөмж
Улиастай	“Очир-Илч”ОНӨ УҮГ	Бараа материал	Жолоочийн тооцоо бодоогүйгээр шатахун зарцуулдаг	0.8	Зөвлөмж өгсөн
Сантмаргац	ЗДТГ	Бараа материал	Жолоочийн тооцоо бодоогүйгээр шатахун зарцуулдаг	7.9	Зөвлөмж өгсөн
Тосонцэнгэл	ЗДТГ	Бараа материал	Жолоочийн тооцоо бодоогүйгээр шатахун зарцуулдаг	9.2	Зөвлөмж өгсөн
Шилүүстэй	ЗДТГ	Бараа материал	Жолоочийн тооцоо бодоогүйгээр шатахун зарцуулдаг	7.1	Зөвлөмж өгсөн
Яруу	ЗДТГ	Бараа материал	Жолоочийн тооцоо бодоогүйгээр шатахун зарцуулдаг	15.4	Зөвлөмж өгсөн
Дүн				84.7	

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “ Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”, 20.1.4 “ Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтууд, “Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм” –ийг зөрчсөн байна

Ес. Үндсэн хөрөнгийн талаар

9.1 Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүн, тайлагналын талаар

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгө 2015 оны эцэст 74379,1 сая төгрөг байсан бол тайлант онд 12,6 хувь буюу 9371,8 сая төгрөгөөр нэмэгдэж 2016 оны эцэст 83750,9 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Нийт үндсэн хөрөнгийн үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр нь харуулбал:

(сая.төг)

Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	
			дүн	Хувь
Барилга байгууламж	59101,1	64940,4	5839,3	9,9
Тээврийн хэрэгсэл	2520,3	2162,0	-358,3	14,2
Машин тоног төхөөрөмж	5602,8	8856,2	3253,4	58,1
Тавилга эд хогшил	2699,7	2757,6	57,9	2,1

Дуусаагүй барилга	19,8	19,8	0	0
Зам, гүүрийн байгууламж	9,6	9,1	-0,5	5,2
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1167,3	1169,3	0	0
Бусад үндсэн хөрөнгө	2046,8	2585,8	539,0	26,3
Ном	1187,1	1231,7	44,6	3,7
Биет бус хөрөнгө	24,4	18,9	-5,5	21,9
Дүн	74379,1	83750,9	9371,8	12,6
Төрийн сан				
Төсөвт байгууллагууд	67293,3	76810,7	9517,4	14,1
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	7085,8	6940,2	-145,6	2,1
Төсөл, сангууд				

Нийт үндсэн хөрөнгө өмнөх оноос 12,6 хувиар өссөн байна. Үүнд: барилга байгууламж 9.9 хувь, машин тоног төхөөрөмж 58,1 хувь, тавилга хэрэгсэл 2,1 хувиар, бусад үндсэн хөрөнгө 26,3 хувиар тус тус өссөн бол тээврийн хэрэгсэл 14.2 хувь, тавилга, эд хогшил 2,1 хувь, зам гүүрийн байгууламж 5,2 хувь, биет бус хөрөнгө 21,9 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Байгууллагын төрлөөр авч үзвэл төсөвт байгууллагуудын үндсэн хөрөнгө өмнөх оноос 9517,4 сая төгрөгөөр буюу 14,1 хувиар өссөн байна.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 20690.8 сая төгрөгөөр нэмэгдсэнийг графикаар харуулбал: /сая төгрөгөөр/



Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө нийт 7101,7 сая төгрөгөөр хасагдаж, тайлант онд 4924,3 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Үндсэн хөрөнгийн хасагдалтыг графикаар харуулбал:



Тайлант онд барилга байгууламж 5839,3 сая төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 3253,4 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт үндсэн хөрөнгийн 77,5 хувийг барилга байгууламж, 3,3 хувийг тавилга, эд хогшил, 10,5 хувийг машин тоног төхөөрөмж эзэлж байгаа бөгөөд үлдэх 8,7 хувийг бусад үндсэн болон биет бус хөрөнгө тус тус эзэлж байна.

9.2 Сумдын ТЕЗ болон орон нутгийн төсөвт байгууллагуудын үндсэн хөрөнгөтэй холбоотой зөрчлийн талаар

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой 295,3 сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1. "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэсэн заалтыг зөрчсөн 227,1 сая төгрөгийн алдаа илэрлээ

- Завханмандал сумын дунд сургууль 3,4 сая төгрөгийн, Баянхайрхан сумын ЗДТГ 70,6 сая төгрөгийн үнэгүй ирсэн үндсэн хөрөнгийг орлогод аваагүй
- Сантмаргац сумын ЗДТГ 1,0 төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод аваагүй шууд зардлаар бүртгэсэн
- АЗДТГ- нь 112,1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хууль бус шийдвэрээр бүртгэлээс хассан.
- Завханмандал сумын ЗДТГ 40,0 сая төгрөгийн үнэ бүхий 2 ш дизель станц тооллогын бүртгэлд байгаа боловч бодитоор оршин байхгүй

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 77 дугаар зүйлийн 77.3-д “Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү ИТХ, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын тэргүүлэгчид шийдвэрлэнэ” гэсэн заалтыг зөрчин холбогдох байгууллагын зохих шийдвэргүйгээр нийт 2,2 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна. Үүнд:

- Цэцэн-Уул сумын дунд сургууль 2,1 сая төгрөгийн, Орон нутгийн өмчийн газар 0,1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тус тус шийдвэргүйгээр худалдан авсан

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5,1,4-т "Үнэн зөв байх" зарчмыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, үнэлгээ, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг зөрчиж үндсэн хөрөнгийн элэгдлийг нийт 48,9 сая төгрөгөөр зөрүүтэй тооцсон дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Тосонцэнгэл сумын 2 дугаар цэцэрлэг 3,2 сая төгрөгийн, Тосонцэнгэл сумын Очирт-Хайрхан ОНӨУҮГ нь 45,7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн буруу тооцсон

Дээрх алдаа зөрчлөөс 112,1 сая төгрөгийн зөрчилд актын төлбөр тогтоож, 48,9 сая төгрөгийн алдааг залруулж, бусад алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

Арав. Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

10.1 Өр, төлбөрийн бүтцийн талаар

Аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 2192,3 сая төгрөг байснаас тайланд онд 34,8 сая төгрөгөөр өсч, оны эцэст 2227,1 сая төгрөгт хүрсэн байна.

Нийт өр, төлбөрийн үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувь
Богино хугацаат өр төлбөр	887,9	922,6	34,7	3,9
Өглөг	887,9	922,6	34,7	3,9
Урьдчилж орсон орлого	-	-	-	-
Урт хугацаат өр төлбөр	1304,4	1304,4	-	-
Урт хугацаат үнэт цаас	-	-	-	-
Урт хугацаат зээл	1304,4	1304,4	-	-
Нийт өр төлбөрийн дүн	2192,3	2227,1	34,8	1,5

Тайлант хугацааны эцэст богино хугацаат өр төлбөр 34,7 сая төгрөгөөр буюу 3,9 хувиар өссөн байна. Нийт өр төлбөрийн 41,4 хувийг богино хугацаат өр төлбөр, 58,6 хувийг урт хугацаат өр төлбөр тус тус эзэлж байна.

Өглөгийн үлдэгдлийг сум тус бүрээр задалж харуулбал:

/сая төгрөг/

Сумын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн, буурсан
Асгат		0.0	-
Баянтэс	13.9		(13.9)
Баянхайрхан	4.7	1.3	(3.4)
Дөрвөлжин	7.5	3.0	(4.5)
Завханмандал	2.9	0.9	(2.0)
Идэр	3.5		(3.5)
Их Уул	11.0	0.1	(10.9)
Нөмрөг		35.5	35.5
Отгон	3.9		(3.9)
Тосонцэнгэл	54.9	284.5	229.6
Түдэвтэй	6.8	0.1	(6.7)
Тэлмэн	2.9		(2.9)
Тэс	1.7	12.1	10.4
Улиастай	390.9	21.5	(369.4)
Ургамал	1.3	1.1	(0.2)
Цагаанчулуут		14.1	14.1
Цэцэн-Уул	9.4	16.6	7.2
Шилүүстэй	16.8	9.3	(7.5)
Эрдэнэхайрхан	15.9	6.5	(9.4)
Яруу		2.4	2.4
Аймгийн төрийн сан	339.9	513.7	173.8
БХӨТ-ийн дүн	887.9	922.7	34.8
Аймгийн төрийн сан	1,304.4	1,304.4	-
УХӨТ-ийн дүн	1,304.4	1,304.4	-
Нийт өр төлбөрийн дүн	2,192.3	2,227.1	34.8

Хүснэгтээс үзэхэд тайлант оны эцэст нийт өр төлбөрийн 513.7 сая төгрөг буюу 55.6 хувь нь аймгийн төрийн сангийн, 284,5 сая төгрөг буюу 30,8 хувь нь Тосонцэнгэл сум, 35,5 сая төгрөг буюу 3,8 хувь нь Нөмрөг сум, 9,8 хувь нь бусад сумдад оногдож байна.

УХӨТ-ийн 1304,4 сая төгрөг нь “Амь-Ус трейд” ХХК-ний дамжуулан зээлдүүлсэн Дэлхийн хөгжлийн банкинд төлөх өр байна.

Аймаг, сумын Засаг дарга нар Төсвийн тухай хуулийн 39.4-т “Аймаг, Нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэхэд дараах шаардлага тавигдана”, 39.4.2-т “Өр, авлага үүсгэхгүй байх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

10.2 Өр, төлбөрийн дансны үлдэгдлийн баталгаажуулалтын талаар

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өглөгийг буруу бүртгэсэн, тайланд тусгаагүй өмнөх оны өрийг санхүүжүүлсэн зэрэг нийт 9,0 сая төгрөгийн зөрчил илэрч, хэмжилт, иж бүрэн байх, тохиолдсон байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна. Үүнд:

- Сантмаргаз сумын дунд сургууль 3,2 сая төгрөгийн, Түдэвтэй сумын дунд сургууль 1,0 сая төгрөгийн тайланд тусгаагүй өмнөх оны өрийг санхүүжүүлсэн
- Тосон-Очирт хайрхан ОНӨУҮГ- нь НДШ-ийн 4,8 сая төгрөгийн өглөгийг илүү бүртгэсэн

Дээрх байдал нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана”, 19 дүгээр зүйлийн 19.1.4-т

Аймгийн аудитын газраас 4,2 сая төгрөгийн зөрчилд акт тогтоож, 1,0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 8,0 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулсан байна.

“...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах”, 19.1.5-д “эд хөрөнгө, өр төлбөрийн хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг бүртгэхгүй байх” Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2-т “Өр, авлага үүсгэхгүй байх” гэсэн заалтыг тус тус хангахгүй байна.

Арван нэг. Орлогын бүртгэл, тайлагнал

11.1 Завхан аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн талаар

2016 оны Завхан аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаарх үйл ажиллагааны орлогын нийт дүн 104216,2 сая төгрөгөөр тайлагнасан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 3815,6 сая төгрөгөөр өссөн байна.

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү	Хувь
Татварын орлого	6,127,1	6771,4	644,3	10,5
Татварын бус орлого	29751,0	28644,1	-1106,9	3,3
Тусламж санхүүжилтийн орлого	64522,6	68800,8	4278,2	6,6


Үйл ажиллагааны орлогын дүн	100400,6	104216,2	3815,6	0,2
------------------------------------	-----------------	-----------------	---------------	------------

Дээрх хүснэгтээс харахад татварын орлого 644,3 сая төгрөг буюу 10,5 хувиар, тусламж санхүүжилтийн орлого 4278,2 сая төгрөг буюу 6,6 хувиар өссөн бол татварын бус орлого 1106,9 сая төгрөг буюу 3,3 хувиар буурсан байна.

Сумдын ТЕЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

ТЕЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд нийт 24 сум, аймгийн төрийн сангийн 104216,2 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого тайлагнагдсан байна.

Нийт орлогын дүнд эзлэх хувийн жинг сумдуудаар харуулбал: өөрчлөх



ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар орлогыг буруу бүртгэсэн, тайланд тусгаагүй, төвлөрүүлэх орлогыг төвлөрүүлээгүй өөрийн орлогын төлөвлөгөөг тасалсан, зэрэг нийт 125,5 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- Аймгийн ОНХС-д 2016 оны 9-р сард 8 сумын ОНХС-аас 71,9 сая төгрөгийг хууль, журмын үндэслэлгүйгээр татан төвлөрүүлсэн.
- Нөмрөг сумын ЗДТГ нэмэлт санхүүжилтийн дансаар орсон 2,5 сая төгрөгийн орлогыг бүртгэлд тусгаагүй.
- Орон нутгийн татварын давсан орлого харьцангуй өндөр дүнтэй сумдын төрийн сангууд тодорхой хувийг сумын ОНХС-д төвлөрүүлээгүй байна. Үүнд:
 - Алдархаан сумын төрийн сан 12,6 сая төгрөгийн,
 - Завханмандал сумын төрийн сан 17,0 сая төгрөгийн,
 - Сантмаргац сумын төрийн сан 15,4 сая төгрөгийн
 - Түдэвтэй сумын төрийн сан 11,1 сая төгрөгийн
 - Тэс сумын төрийн сан 27,0 сая төгрөгийн
 - Ургамал сумын төрийн сан 12,0 сая төгрөгийн
 - Шилүүстэй сумын төрийн сан 47,9 сая төгрөгийн

- Эрдэнэхайрхан сумын төрийн сан 51,7 сая төгрөгийн тус тус татварын давсан орлоготой байна.

Дээрх байдал нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60,2. /Орон нутгийн хөгжлийн сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ/, 60,2,4./татварын хувьт хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр/гэсэн заалтуудыг хангаагүй байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого тасарсан байгууллагууд байна. Тухайлбал,

- ХЖТеатр 6,8 сая төгрөгөөр
- Отгон, Тосонцэнгэл сумын 2,3-р цэцэрлэгүүд тус бүр 0,1 сая төгрөгөөр тус тус тасарчээ

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аймгийн аудитын газраас 79,0 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгч, 2,5 сая төгрөгийн зөрчийг санхүүгийн тайланд залруулсан байна.

Арван хоёр. Зардлын бүртгэл, тайлагнал

12.1 Зардлын бүтцийн талаар

Завхан аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайланд нийт зардал 93031,3 сая төгрөгийн зарцуулалттай тайлагнагдсан нь өмнөх оноос 3981,8 сая төгрөгөөр өссөн байна.

Завхан аймгийн ТЕЗ-ийн 2015 оны төсвийн нийт зарцуулалтыг үр дүнгийн тайланд тайлагнасны дагуу нийт зардлыг эдийн засгийн ангиллаар өмнөх болон тайлант оны зардлын эзлэх хувийг хүснэгт №1, график №1-ээр харуулав.


Нийт зардлыг бүтэцээр нь харуулбал:

Хүснэгт №1 /сая төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	ЭЗЛЭХ ХУВЬ
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	89049,5	93031,3	
УРСГАЛ ЗАРДАЛ	82859,3	88400,5	95,0
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47511,3	51341,2	55,2
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	28744,9	28787,6	30,9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3186,1	3160,7	3,4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3303,5	5026,8	5,4
Хангамж, бараа материалын зардал	1354,3	1495,2	1,6

Нормативт зардал	2633,9	2593,5	2,8
Эд хогшил, урсгал засварын зардал	305,4	304,2	0,3
Томилолт, зочны зардал	247,5	209,7	0,2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2802,3	2380,0	2,6
Бараа үйлчилгээний бусад зардал	4933,5	7383,5	7,9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6190,1	4630,8	5,0
ТАТААС	0,04	20,0	0,02
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35343,5	37039,3	39,8

График №1 /сая төгрөгөөр/



Дээрх хүснэгт №1, график №1-ээс харахад нийт зардлаас хамгийн өндөр хувийг эзэлж байгаа зардлууд нь цалингийн зардал 28787,6 сая төгрөг буюу 30,9 хувь, хөрөнгийн зардал 4630,8 сая төгрөг буюу 5 хувь, урсгал шилжүүлэг 37039,3 сая төгрөг буюу 39,8 хувийг тус тус эзэлж байна.

Сумдын зардлыг харьцуулбал:

Хүснэгт №2 /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү
Алдархаан	1,406.5	1,536.4	129,9
Асгат	1,045.6	1,376.7	331,1
Баянтэс	1,630.1	2,235.3	605,2
Баянхайрхан	945.8	1,596.1	650,3
Тосонцэнгэл	4,256.6	4,996.4	739,8
Дөрвөлжин	1,858.9	1,941.7	82,8
Завханмандал	1,270.5	1,413.6	143,1

Идэр	1,796.7	1,884.3	87,6
Их Уул	3,213.5	3,212.4	-1,1
Нөмрөг	1,770.5	2,045.0	274,5
Отгон	1,822.5	1,887.9	65,4
Сантмаргац	1,696.9	1,819.6	122,7
Сонгино	1,747.8	1,698.2	-49,6
Түдэвтэй	1,655.1	1,584.4	-70,7
Тэлмэн	2,032.0	1,896.0	-136,0
Тэс	2,227.1	2,384.8	157,7
Улиастай	9,923.0	10,910.7	987,7
Ургамал	1,102.6	1,439.0	336,4
Цагаанхайрхан	1,279.9	1,396.7	116,8
Цагаанчулуут	1,482.5	1,514.6	32,1
Цэцэн-Уул	1,706.1	1,762.9	56,8
Шилүүстэй	1,746.6	1,566.8	-179,8
Эрдэнэхайрхан	1,567.9	1,615.1	47,2
Яруу	1,110.2	1,622.5	512,3
Аймгийн төрийн сан	38,754.3	37,694.4	-1059,9
Дүн	89,049.2	93,031.5	3982,3

Дээрх хүснэгт №2 -ээс харахад нутаг дэвсгэр, хүн ам, эдийн засгийн статусаар ялгаатай тул Төрийн сан, Улиастай, Тосонцэнгэл, Их-Уул сумд бусад сумдаас өндөр зарцуулалттай байна.

12.2 Завхан аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар зардалтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар зардлын данстай холбоотой нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, журам, заавар мөрдөөгүй, дансны бичилт буруу хийсэн, анхан шатны баримтын бүрдүүлбэр дутуу, төсвийг зориулалт бусаар, үрэлгэн, үр ашиггүй зарцуулсан зэрэг нийт 235,0 сая төгрөгийн алдаа, зөрчлүүд илэрч үнэн зөв байдал, толилуулга, хэмжилт, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

12.3 Зардалтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар

Бүрдүүлбэр дутуу анхан шатны баримтаар зардал гаргасан:

- Алдархаан сумын ЗДТГ 4,0 сая төгрөгийн, Баянхайрхан сумын ЗДТГ 1,1 сая төгрөгийн, аймгийн ЗДТГ 21,3 сая төгрөгийн, Улиастай сумын 3-р сургууль 2,2 сая төгрөгийн зардлыг тус тус бүрдэл дутуу анхан шатны баримтаар зарлагдсан

Санхүүгийн тайланд зардлыг зөрүүтэй илэрхийлсэн:

- Мөнгөн гүйлгээний тайланд Баянтэс сумын дунд сургууль 1,1 сая төгрөгийн, Шилүүстэй сумын дунд сургууль 8,5 сая төгрөгийн, ХТҮА 0,2 сая төгрөгийн зардлыг зүйл анги хооронд гүйлгэн зарцуулсан

- Үр дүнгийн тайланд Шилүүстэй сумын сургууль 11,2 сая төгрөгийн, Улиастай 3-р сургууль 0,2 сая төгрөгийн, Тосонцэнгэл сумын 5-р цэцэрлэг 1,0 сая төгрөгийн зардлыг зүйл ангийн хооронд гүйлгэн зарцуулсан
- Тосонцэнгэл сумын 1-р цэцэрлэг 0,2 сая төгрөгөөр, 4-р цэцэрлэг 0,8 сая төгрөгөөр үр дүнгийн зардлыг зөрүүтэй тусгасан

Цалингийн зардлаас цалин, урамшуулал илүү олгосон болон зардал гаргасан:

- Баянхайрхан сумын ЗДТГ 0,9 сая төгрөгийн, Шилүүстэй сумын цэцэрлэг 0,7 сая төгрөгийн цалингийн урьдчилгаа суутгаагүйгээр цалингийн зардалд бүртгэсэн.
- Алдархаан сумын дунд сургууль 2,4 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал, ур чадварыг хавтгайруулан олгосон
- Цалингийн зардлаас Сантмаргац сумын ЗДТГ 0,6 төгрөгийг, Цэцэн-Уул сумын ЗДТГ 0,7 сая төгрөгийг гадаад явах сургалтын зардалд дэмжлэг үзүүлсэн

Зориулалт бус буюу үрэлгэн зарцуулсан зардлын талаар

- Аймгийн ЗДТГ ЗГ-ын 2016 оны 47 тоот тогтоолыг зөрчин 55,7 сая төгрөгөөр урсгал засвар хийж хөрөнгө бэлтгэсэн, ажлаас чөлөөлөгдсөн хүмүүст үндэслэлгүйгээр 6 сарын тэтгэмжид 31,7 сая төгрөгийг олгосон
- Улиастай сумын ЗДТГ ажлаас чөлөөлөгдсөн хүмүүст үндэслэлгүйгээр 6 сарын тэтгэмжид 5,8 сая төгрөг олгосон
- Аймгийн замын сангаас 33,0 сая төгрөгийг үр дүн, үр ашиггүй зарцуулсан
- Аймгийн Засаг даргын нөөц сангаас 0,3 сая төгрөгийг үрэлгэн зарцуулсан
- Их-Уул сумын төрийн сан орон нутгийн татварын давсан орлогоос 10,5 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд үрэлгэн зарцуулсан

Сургуулийн хүүхдийн хоол зардлын талаар

- Алдархаан сумын дунд сургууль 5,8 сая төгрөгийн үдийн цай, байрны хүүхдийн хоолны зардлыг нормативаар зарцуулаагүй, хоолны зарцуулалтын тайланг ауруу тайлагнасан
- Асгат сумын дунд сургууль 13,8 сая төгрөгөөр хүүхдийн хоолны зардлыг илүү тооцсон

Дээрх алдаа зөрчлүүд нь Цалин, хангамж, тэтгэмж урамшуулал, зочны болон нормативт зардлуудыг зарцуулахдаа Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 6 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Аж ахуйн нэгж байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө НББОУС-ын дагуу үнэлж, дансанд тусгана”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг

хэрэгжүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн нь үнэн зөв байдал гэсэн батламж

Аймгийн аудитын газраас 41,6 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулж, 99,5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн, 90,2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 32,7 сая төгрөгийн зөрчилийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгч ажилласан байна.

мэдэгдлийг хангахгүй байна.

12.4. Хуримтлагдсан үр дүнгийн талаар

2016 оны ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн өмчийн өөрчлөлтийн тайлангаар тайлант үеийн үр дүн 10952,7 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хуримтлагдсан үр дүн 29384,1 сая төгрөг болсон байна.

12.5 Завхан аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлын талаар

Аймгийн Төрийн сангийн дансдын ажил гүйлгээг түүвэрчлэн үзэхэд 2016 онд хөрөнгө оруулалтын техник хяналтын зардлын мөнгийг 2 өөр дансанд төвлөрүүлж зарцуулсан бөгөөд эндээс ХО-ын ажлуудын зураг төсөв, экспертиз хийлгэх, зохиогчийн хяналтын зардал хийлгэх зэрэгтэй холбоотой 24,5 сая төгрөгийг гаргасан боловч холбогдох газруудаас авахаар авлага үүсгээгүй, Идэр сумын цэцэрлэгийн засварын санхүүжилтийн дутуу 9,9 сая төгрөг, Улиастай сумын ЗДТГ болон ХТҮАлбаны конторын барилгын халаалтын засварын ажлуудад 18,1 сая төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 2016 оны 9-р сард 8 сумын орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл 71,9 сая төгрөгийг төвлөрүүлсэн зөрчилтэй байна.

Богино хугацаат авлагын үлдэгдэл 153,7 сая төгрөг эзэн тодорхойгүй он дамжсан авлага байна.

Арван тав. ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн талаар

Завхан аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн төсвийн байгууллага 65, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага 118, халамжийн сан, аймгийн болон ОНХСан, сум хөгжүүлэх сан ,төрийн сангийн төвлөрүүлсэн тайлан 25, Төрийн болон ОНӨҮГ 6 нийт 215 нэгж байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.Үүнээс:

- ✓ Орон нутгийн төсөвт байгууллага 65
- ✓ ТӨҮГ-3
- ✓ ОНӨҮГазар-4
- ✓ Тусгай шилжүүлэг-118
- ✓ Сумын ТТЗ буюу төрийн сангийн нэгж-25 буюу нэгдсэн тайланд нэгтгэгдсэн нийт байгууллагаас 143 байгууллага буюу 66,5 хувийн санхүүгийн тайланд аймгийн Аудитын газар аудит хийж, үлдэх 33,5

хувь буюу 72 нэгжид хувийн аудитын 3 компани аудитыг тус тус хийсэн байна.

Аймгийн аудитын газраас аймгийн ТЭЗ-ийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийж 2872,3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 225,2 сая төгрөгийн материаллаг алдааг залруулж, 2647,2 сая төгрөгийн материаллаг бус зөрчил, дутагдлыг арилгах зөвлөмж өгсөн байна.

Аудитаар ТЭЗ-ийн харьяа байгууллага, сумдын ТЭЗ-ийн нийт 215 санхүүгийн тайланд хийсэн аудитаар 121 тайланд зөрчилгүй, 7 тайланд зөрчилтэй, 4 тайланд хязгаарлалттай, 1 тайланд татгалзсан, 18 тайланд санал дүгнэлт өгөөгүй түүвэр аудит хийсэн байна.

Аудитаар 244,9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож 602,3 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

Аудитын явцад хийсэн сорилын үр дүнд санхүүгийн тайлангийн зарим батламж мэдэгдэлтэй зөрчилдсөн материаллаг хэмжээний алдаа, зөрчлүүд илэрсэн зарим ТШЗ-ийн 2016 оны санхүүгийн тайланд зөрчилтэй буюу хязгаарлалттай, санал өгөхөөс татгалзсан зэрэг санал дүгнэлт өгөхөд хүргэлээ. Үүнд:

“Зөрчилтэй” санал дүгнэлт авсан байгууллагын жагсаалт:

№	“Зөрчилтэй” санал дүгнэлт авсан ТШЗ	“Зөрчилтэй” санал дүгнэлтийн шалтгаан
	Аймгийн ЗДТГ	- ЗГ-ын 2016 оны 47 тоот тогтоолыг зөрчин 55,7 сая төгрөгөөр урсгал засвар хийж хөрөнгө бэлтгэсэн - 112,1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үндэслэлгүйгээр бүртгэлээс хассан - 21,3 сая төгрөгийн ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл дутуу - 12,9 сая төгрөгөөр төсвийг хэтрүүлэн зарцуулсан - Ажлаас чөлөөлөгдсөн хүмүүст 6 сарын тэтгэмжид 31,7 сая төгрөгийг олгосон - Төсвийн урсгал санхүүжилтийн болон нэмэлт санхүүжилтийн дансаар 140,6 сая төгрөгийн гадны гүйлгээ хийгдсэн
	Замын сан	➤ Аймгийн төвийн болон сумдын замын хэвтээ, босоо тэнхлэгийн тэмдэг тэмдэглэгээг шинэчлэх ТАХ-д 20,0 сая төгрөгийг олгосон бөгөөд ажил хийгдээгүй ➤ 103,4 сая төгрөгийн 4 ТАХ-ний ажил хийгдсэн боловч ажлын гүйцэтгэлийг гаргаж хянаагүй, улсын комисс хүлээн аваагүй
	Орон нутгийн өмчийн газар	➤ 1.1 сая төгрөгийн бараа материалыг дансаар дамжуулаагүй шууд зардалд бүртгэсэн ➤ 3.0 сая төгрөгийн үндэслэлгүй авлага үүсгэсэн ➤ 0.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шийдвэргүйгээр бэлтгэсэн

	Алдархаан сумын сургууль	➤ 5,8 сая төгрөгийн үдийн цай, байрны хүүхдийн хоолны зардлыг нормативаар зарцуулаагүй, хоолны зарцуулалтын тайланг буруу тайлагнасан ➤ 2,4 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал, ур чадвар хавтгайруулан олгосон ➤ 6,8 сая төгрөгийг анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан
	Асгат сумын сургууль	➤ Хүүхдийн хоолны зардлыг 13,8 сая төгрөгөөр илүү тооцсон
	Тосонцэнгэл сумын “тосоночирт хайрхан” ОНӨААТҮГ	➤ Бараа материйлын үлдэгдлийг 2.5 сая төгрөгөөр дутуу, үндсэн хөрөнгийн тайлант оны элэгдлийн зардлыг 45.8 сая төгрөгөөр алдаатай илэрхийлсэн, өмнөх үеийн ашгийг 4.7 сая төгрөгөөр алдаатай илэрхийлсэн
	Амь-Ус ХХК ОНӨҮГ	➤ 15.6 сая төгрөгийн хөрөнгө бодитойгоор оршин байгаагүй, 0.3 сая төгрөгийн авлагыг дутуу бүртгэсэн, ➤ 6.7 сая төгрөгийн найдваргүй авлагыг барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй, ➤ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтуудыг 72.7 сая төгрөгөөр

“Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байгууллагын жагсаалт:

№	“Хязгаарлалттай” санал, дүгнэлт авсан ТШЗ	“Хязгаарлалттай” санал, дүгнэлтийн шалтгаан
1	Алдархаан сумын ЗДТГ	➤ Кассаас бэлэн мөнгийг үндсэн баримтгүйгээр зарцуулсан ➤ Сумын ахмадуудад түлээний үнийн хөнгөлөлтийг хавтгайруулан 40 иргэнд 4,0 сая төгрөгийг баримтын бүрдэл дутуу олгосон ➤ Батлагдсан төсвийн зардлыг 14,5 сая төгрөгөөр хэтрүүлсэн
2	Баянхайрхан сумын ЗДТГ	- 3,3 сая төгрөгийн ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл дутуу ➤ Цалингийн урьдчилгаа хавтгайруулан олгож 2 ажилтаны цалингийн урьдчилгаа 0,9 сая төгрөгийг суутгалгүйгээр цалингийн зардалд бүртгэсэн ➤ 1,1 сая төгрөгийг кассаас үндсэн баримтгүйгээр зарцуулсан ➤ Жилийн эцсийн санхүүгийн тайланг Аудитын газарт 2 жил дараалан 25-30 хоногоор хоцроон ирүүлсэн

		➤ 70,6 сая төгрөгийн үнэ төлбөргүйгээр ирсэн үндсэн хөрөнгийг орлого аваагүй байсныг залруулсан
3	Завханмандал сумын ЗДТГ	➤ 40,0 сая төгрөгийн үнэ бүхий 2 ш дизель станц тооллогын бүртгэлд байгаа боловч бодитоор оршин байхгүй
4	Улиастай 3-р сургууль	➤ Үр дүнгийн тайланд 0,2 сая төгрөгийн зардлыг зүйл ангийн хооронд гүйлгэн зарцуулсан ➤ 2,2 сая төгрөгийг анхан шатны баримтгүйгээр зарцуулсан ➤ 5,6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тодруулгад дутуу илэрхийлсэн

“Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” санал дүгнэлт авсан байгууллагын жагсаалт:

№	“Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан”	“Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлтийн шалтгаан
1	Шилүүстэй сумын сургууль	➤ Үр дүнгийн тайланд 11,2 сая төгрөгийн зардлыг зүйл ангийн хооронд гүйлгэн тайлагнасан ➤ Мөнгөн хөрөнгийн тайланд 8,5 сая төгрөгийн зардлыг зүйл агнийн хооронд гүйлгэн тайлагнасан

Арван зургаа. Аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн санал, дүгнэлт

Аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2016 оны үр дүнгийн тайланд нэгтгэсэн нийт орлогыг материаллаг байдлын суурь болгон авч, түүний 1.0 хувиар сонгон 1042,2 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 2842,5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнээс 1859,8 сая төгрөгийн зөрчил алдаа нь материаллаг бус шинж чанартай, 982,7 сая төгрөгийн алдаа зөрчил нь материаллаг чанартай тул аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч байна. Зөрчлийг ангилавал:

- Мөнгөн хөрөнгийн дансанд буюу зарцуулахтай холбоотой илэрсэн 263,4 сая төгрөгийн зөрчил
- Авлагатай холбоотой 1829,6 сая төгрөгийн
- Бараа материалын дансны бүртгэл, зарцуулахтай холбоотой 84,7 сая төгрөгийн
- Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 295,3 сая төгрөгийн
- Өр, төлбөрийн бүртгэлтэй холбоотой 9,0 сая төгрөгийн
- Орлогын бүртгэлтэй 125,5 сая төгрөгийн
- Зардлын данс буюу зарцуулахтай холбоотой 235,0 сая төгрөгийн зөрчил тус тус илэрсэн байна.

Арван долоо. Тайлант оны аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн ЗДТГ-ын СТСангийн хэлтэст:

1. Аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 2016 онд хөрөнгө оруулалтын техник хяналтын зардлын мөнгийг 2 өөр дансанд төвлөрүүлж зарцуулсан бөгөөд эндээс ХО-ын ажлуудын зураг төсөв, экспертиз хийлгэх, зохиогчийн хяналтын зардал хийлгэх зэрэгтэй холбоотой 24,5 сая төгрөгийг гаргасан боловч холбогдох газруудаас авахаар авлага үүсгээгүй, Идэр сумын цэцэрлэгийн засварын санхүүжилтийн дутуу 9,9 сая төгрөг, Улиастай сумын ЗДТГ болон ХТҮАлбаны конторын барилгын халаалтын засварын ажлуудад 18,1 сая төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд 24,5 сая төгрөгийн авлагыг тусгаж залруулах, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг таслан зогсоох

2. Аудитаар авлагатай холбоотой 1829,6 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь нийт зөрчлийн 64,3 хувийг эзэлж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д заасан “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй буюу үнэн зөв байдал, толилуулга, эрх ба үүрэг, хэмжилт, иж бүрэн байх гэсэн батламж мэдэглийг хангаагүй, Сангийн сайдын 388 дугаар тушаалаар баталсан НББ-ийн зааврыг зөрчсөн байна.

➤ **Шийдвэрлэсэн нь:** Аймгийн төрийн санд бүртгэлтэй 153,7 сая төгрөгийн он дамжсан эзэн тодорхойгүй авлагыг тодруулж шийдвэрлэх. Сумдын СХС-ийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг барагдуулах талаар сумдын санхүүгийн албатай хамтран тодорхой ажил зохион байгуулж ажиллах

3. Аудитаар аудитаар илэрсэн бусад алдаа, зөрчил нь анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийх, тогтмол зардлуудыг шууд зардалд хаах, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар үрэлгэн зарцуулах, цалингийн урьдчилгааг суутгалгүйгээр зардалд шууд бүртгэх, зардлыг зүйл ангийн хооронд гүйлгэн зарцуулах зэрэг зөрчлүүд эзэлж байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Аж ахуйн нэгж байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө НББОУС-ын дагуу үнэлж, дансанд тусгана”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх” гэсэн заалтууд, УСНББОУС-1, Иж бүрэн байх, толилуулга, үнэлгээ, эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлийг хангаагүй, СС-ын 2006

оны 388-р тушаалын 1-р хавсралтаар баталсан НББ-ийн зааврын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар гарсан дээрх нийтлэг зөрчлийг арилгах талаар аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс сумдын санхүүгийн алба, нягтлан бодогч нарт мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах

Завхан аймгийн Засаг дарга, ТЕЗ Д.Батсайхан-д:

1. Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар аймгийн ОНХС-д 2016 оны 9-р сард 8 сумын ОНХС-аас 71,9 сая төгрөгийг хууль, журмын үндэслэлгүйгээр төвлөрүүлжээ.
Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Сумдад хуваарилагдсан ОНХС-ийн хөрөнгөөс аймгийн ОНХС-д татан төвлөрүүлэх ажиллагааг таслан зогсоох

2. Орон нутгийн татварын давсан орлого харьцангуй өндөр дүнтэй сумдын төрийн сангууд тодорхой хувийг сумын ОНХС-д төвлөрүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60,2. /Орон нутгийн хөгжлийн сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ/; 60,2,4./татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр/ гэсэн заалтуудыг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн болон сумдын орон нутгийн татварын давсан орлогын тодорхой хэсгийг ОНХСанд төвлөрүүлэх талаар даалгавар хүргүүлэх

Завхан аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд

Аудит хийсэн багийн гишүүд:

Ахлах аудитор
Аудитор
Аудитор

Г.Хашцэцэг
Ч.Бямбасүрэн
Н.Батбилэг